



# ГАЛТ ТЭРЭГНИЙ ХӨДӨЛГӨӨН ЗОХИЦУУЛАЛТЫН НЭГДСЭН ТӨВ



E-NEWSLETTER

f facebook.com/Rtcc.m0n  
🌐 <http://rtcc.mrtcd.gov.mn>  
✉ [info@rtcc.mrtcd.gov.mn](mailto:info@rtcc.mrtcd.gov.mn)  
☎ +976 77244409

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТОВЧ ТАЙЛАН  
2019 оны аравдугаар сарын дугаар

## Төвийн үйл ажиллагаа



MNS ISO 3646 Ачааны чингэлэг, тодорхойлолт, тэмдэг тэмдэглэгээ стандартын хэлэлцүүлэг боллоо.

ТЗДАБУЗТ СТХ-ны 2019.10.18-ны хурлаар MNS ISO 3646 АЧТТТ стандартын төслийг хэлэлцүүлэв. Стандартын төслийг техникийн хорооны гишүүдийн 100 хувийн саналаар үндэсний стандартаар батлахаар шийдвэрлэгдлээ.



"Давхар ачилгат чингэлгийн вагоныг төмөр замын тээвэрт нэвтрүүлэх тооцоо судалгаа" ажлын хүрээнд ОХУ-ын дэд эрдэмтэн Аршинцев Д.Н -ийн "Чингэлгийн галт тээргэний аюулгүй байдлыг хангах, чингэлэг тээврийн үр ашгийг нэмэгдүүлэх аргууд" сэдэвт эрдмийн ажлын эх хувийг худалдан авч манай орны нөхцөлд өгөгдлийг өөрчлөн тооцоолол гүйцэтгэж байна.



СХГ-ын сургалтад Төвийн мэргэжилтнүүд хамрагдлаа.

Стандартчлал хэмжилзүйн газраас 2019 оны 9 дүгээр сарын 26-27-нд, 10 дугаар сарын 16-17-нд зохион байгуулсан "MNS ISO/IEC 17020:2013 Тохирлын үнэлгээ. Хяналтын ажил эрхэлдэг төрөл бүрийн байгууллагын ажиллагаанд тавих шаардлага", "MNS ISO/IEC 17025:2018 Сорилтын болон шалгалт тохируулгын лабораторийн чадавхид тавих ерөнхий шаардлага" стандартын сургалтад төвийн холбогдох мэргэжилтнүүд хамрагдлаа.





Төмөр замын тээврийн нийтлэг багц 11 дүрэм, журмыг харьцуулан боловсруулж ЗТХЯ-ны ТЗДТБХЗГ-т танилцууллаа.

Төмөр замын тээврийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх хэсгийн 15.1.7-15.1.16-д заасан төмөр замын тээврийн нийтлэг багц 11 дүрэм, журмын харьцуулалт боловсруулж, тулгалт хийж ЗТХЯ-ны ТЗДТБХЗГ-т танилцуулав. Үүнд:

- ЗТ-ийн сайдын 2014 оны 216 дугаар тушаалаар баталж хүчингүй болсонд тооцсон Галт тэрэгний зурмаг зохицуулалтын журмыг ЗТХ-ийн сайдын 2018 оны 264 дүгээр тушаалын 8 дугаар хавсралтаар батлагдсан журамтай,
- ЗТХ-ийн сайдын 2017 оны 140 дүгээр тушаалаар баталж хүчингүй болсонд тооцсон Суурь бүтэц ашиглуулах журмыг ЗТХ-ийн сайдын 2018 оны 264 дүгээр тушаалын 9 дүгээр хавсралтаар батлагдсан журамтай,
- ЗТ-ийн сайдын 2015 оны 188 дугаар тушаалаар баталж хүчингүй болсонд тооцсон Суурь бүтэц ашиглалтын тариф тогтоох аргачлалыг ЗТХ-ийн сайдын 2018 оны 264 дүгээр тушаалын 10 дугаар хавсралтаар батлагдсан аргачлалтай,
- ЗТ-ийн сайдын 2012 оны 120, ЗТХ-ийн сайдын 2017 оны 250 дугаар тушаалаар баталж хүчингүй болсонд тооцсон Төмөр замын тээврийн аюулгүй байдалтай холбоотой зарим объект, үйл ажиллагаанд гэрчилгээ олгох журмыг ЗТХ-ийн сайдын 2018 оны 264 дүгээр тушаалын 11 дүгээр хавсралтаар батлагдсан журамтай,
- ЗТХ-ийн сайдын 2017 оны 205 дугаар тушаалаар баталж хүчингүй болсонд тооцсон Төмөр замын аюултай бүс, төмөр замын зурвас газар, аюулгүйн бүсэд төмөр замын болон бусад объект байрлуулах, үйлдвэрлэл, үйлчилгээ явуулах, нэвтрэх журмыг ЗТХ-ийн сайдын 2018 оны 264 дүгээр тушаалын 12 дугаар хавсралтаар батлагдсан журамтай,
- ЗТ-ийн сайдын 2014 оны 234 дүгээр тушаалаар баталж хүчингүй болсонд тооцсон Монгол улсын хилээр нэвтрэх буй хөдлөх бүрэлдэхүүний бүртгэл хөтлөх, хүлээлцэх журмыг ЗТХ-ийн сайдын 2018 оны 264 дүгээр тушаалын 13 дугаар хавсралтаар батлагдсан журамтай,
- ЗТАЖ-ын сайдын 2008 оны 88 дугаар тушаалаар баталж хүчингүй болсонд тооцсон Галт тэрэгний болон сэлгээний хөдөлгөөнтэй шууд холбоотой ажилтны сахилгын тусгай журмыг ЗТХ-ийн сайдын 2018 оны 264 дүгээр тушаалын 14 дүгээр хавсралтаар батлагдсан журамтай,
- ЗТБХБ-ын сайдын 2011 оны 151 дүгээр тушаалаар баталж хүчингүй болсонд тооцсон Суурь бүтэц эзэмшигч, тээвэрлэгч хоорондын хамтран ажиллах гэрээний үлгэрчилсэн загварыг ЗТХ-ийн сайдын 2018 оны 264 дүгээр тушаалын 15 дугаар хавсралтаар батлагдсан журамтай,

# Төвийн үйл ажиллагаа

- ЗТ-ийн сайдын 2014 оны 225 дугаар тушаалаар баталж хүчингүй болсон тооцсон Төмөр замын байгууллагууд харилцан мэдээлэл солилцох журмыг ЗТХ-ийн сайдын 2018 оны 264 дүгээр тушаалын 16 дугаар хавсралтаар батлагдсан журамтай,

- ЗТХ-ийн сайдын 2018 оны 264 дүгээр тушаалын 7 дугаар хавсралтаар батлагдсан Төмөр замын тээвэр зуучлалын үйл ажиллагааны журам, мөн тушаалын 17 дугаар тушаалаар батлагдсан Төмөр замын мэргэжилтэй ажилтан бэлтгэх, сургалт явуулах, шалгалт авах журам эдгээр болно.


## NEWS Төвийн бусад албан хэргийн хүрээнд авч хэрэгжүүлсэн ажлууд

Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 293 дугаар тушаалаар “ГТХЗНТ” УТУГ-ын зохион байгуулалтын бүтэц, “ГТХЗНТ” УТУГ-ын захирлын 2019 оны А/53 дугаар тушаалаар “ГТХЗНТ” УТУГ-ын ажил, албан тушаалын жагсаалт шинэчлэн батлагдсантай холбогдуулан Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 03 дугаар тогтоолд нийцүүлэн ЗСХ, ТНУАСХ, ГХБАБМХ-ийн даргын албан тушаалын тодорхойлолтын төсөл боловсруулж удирдлагад танилцуулав.

“ГТХЗНТ” УТУГ-ын албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаа, ил тод байдлын шалгуур үзүүлэлтүүд, шилэн дансны хөтлөлт, аудит, хяналт-шалгалтын санал зөвлөмжийн хэрэгжилтэд хийсэн дотоод хяналтын тайланг нийт ажилтанд танилцуулав.

№	АЖИЛ ДАМСНЫ НЭГЭЭЛЭЛТ/ТАВЦ	2019			2018			2017			2016			2015			2014
		1 сар	2 сар	3 сар	1 сар	2 сар	3 сар	1 сар	2 сар	3 сар	1 сар	2 сар	3 сар	1 сар	2 сар	3 сар	
1	Дотоод хяналтын төсөл (Бүтэн жилээр)	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
2	Төрийн байгуулалтын баталгасны төсөл, гүйцэтгэл, хяналт хяналтын шалтгаан тайлбарын ажлыг (Бүтэн жилээр, жил бүр жилээр, жил бүр сар бүр)	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓
3	Төрийн хяналтын төсвийн эрх зүйн хяналтын төсөл (Энгийн жил)	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
4	Өмнөх жил төсвийн зарлалтын хяналтын төсөл, үйл ажиллагааны зорилго, дотоод хяналтын үнэмлэхүй зорилго, зорилго, үйл ажиллагааны зорилго (Бүтэн жилээр, жил бүр жилээр, жил бүр сар бүр)	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓
5	Хяналтын төсвийн хяналтын төсөл, үйл ажиллагааны зорилго, зорилго, үйл ажиллагааны зорилго (Бүтэн жилээр, жил бүр жилээр, жил бүр сар бүр)	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
6	Шалтгааны зорилго, зорилго, үйл ажиллагааны зорилго, зорилго, үйл ажиллагааны зорилго (Бүтэн жилээр, жил бүр жилээр, жил бүр сар бүр)	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓
7	Салбарын тайлан (Бүтэн жилээр, жил бүр жилээр, жил бүр сар бүр)	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
8	Салбарын тайлан, хяналтын зорилго, зорилго, үйл ажиллагааны зорилго (Бүтэн жилээр)	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
9	Байгуулалтын баталгасны төсөл (Бүтэн жилээр)	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-

Төсвийн тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.3-т заасны дагуу төсвийн шууд захирагчийн үр дүнгийн гэрээг 2019 оны жилийн эцсээр үнэлж дүгнэх, зохион байгуулалтын бүтцийн нэгжүүдийн сарын ажлын төлөвлөгөө, захирлын тушаал, гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний санал зөвлөмжийг хэрэгжүүлэх зорилгоор “Ажил эрчимжүүлэх тухай” захирлын 2019 оны А/62 дугаар тушаалыг батлуулж холбогдох арга хэмжээг хэрэгжүүлж байна.



## Төвийн үйл ажиллагаа



Тавантолгой - Зүүнбаян чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтын ажлын үйл явцтай танилцлаа.

Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулга, Зам, тээврийн хөгжлийн сайд Б.Энх-Амгалан, суурь бүтэц эзэмшигч болон төмөр замын мэргэжилтнүүдтэй хамт 2019 оны 10 дугаар сарын 22-ны өдөр Тавантолгой - Зүүнбаян чиглэлийн төмөр замын ажлын явцтай танилцав.



Төмөр замын бүтээн байгуулалтын ажилд 2019 оны 10 дугаар сарын 24-ний өдрийн байдлаар 30 гаруй аж ахуй нэгж, 1815 ажилтан 997 техник, машин механизм ажиллаж байна.



Төмөр замын суурь далангийн ажил хэсэг тус бүрийн гүйцэтгэж буй ажлаас хамааран 2-80 хувийн гүйцэтгэлтэй байна.





БНСУ-ын “Электроник, Харилцаа Холбооны Судалгааны Институт” -тэй хөдлөх бүрэлдэхүүнийг алсын зайнаас хянах, удирдах технологийн талаар санал солилцлоо.

“ГТХЗНТ” УТУГ-ын захирал А.Буяннэмэх 2019 оны 10 дугаар сарын 17-ны өдөр БНСУ-ын “Электроник, Харилцаа Холбооны Судалгааны Институт”-ын /ETRI/ Хүрээлэн буй Орчны Мэдээлэл Технологийн Судалгааны багийн удирдагч, инженерүүдийн холбооны дарга, доктор профессор Ким Ионг-Ил-тэй уулзалт зохион байгуулж утасгүй мэдрэгч сүлжээ ашиглан хөдлөх бүрэлдэхүүнийг алсын зайнаас хянах, удирдах, галт тэрэгний хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахад зориулагдсан температур мэдрэгч болон чичиргээ мэдрэгч ашиглан гэмтэл илрүүлэх технологийн талаар санал солилцлоо.



“ETRI” (Electronics and Telecommunications Research Institute) судалгааны хүрээлэнгээс Төвийн захирлыг БНСУ-д хүрэлцэн ирж, төмөр замд ашиглагдаж байгаа утасгүй мэдрэгчид суурилуулсан технологиудтай танилцахыг санал болгосон.



“Ашиглалтын ажлын үндсэн үзүүлэлтүүд” сэдвээр сургалт зохион байгууллаа.

Төмөр замын ахмад инженер Ч.Лхагвасүрэн төмөр замын ашиглалтын ажлын зорилго, үндсэн үзүүлэлтийн талаар сургалт зохион байгууллаа. Сургалтад төвийн хамт олон идэвхтэй оролцож, оюундаа хөрөнгө оруулалт хийж, мэдлэг нэмсэн үр дүнтэй сургалт болж өндөрлөлөө.





1890 он. Хаант Орос улс төр - хувийн хэвшлийн үр дүнтэй хамтын ажиллагааны дүнд Европын хэсэгтээ 30,000 орчим километр төмөр зам сүлжээг бий болгож, олон хотууд өөр хоорондоо холбогдсон байлаа. Харин Уралын нурууны зүүн хэсэг буюу Азийн хэсэгт ганц ч километр төмөр замгүй байсан юм.



### “АЛСЛАГДСАН АРАЛ”

Уралын нуруунаас цааш зөвхөн морин тэргээр Сибирийг гаталдаг байв. Дараа нь Байгаль нуураас Амар мөрөн, Шилка голыг дамжсан усан замаар Владивосток хүрнэ. Өвөл нь гол хөлдөхөд, зун усгүй болоход холбоо харилцаа бүрэн тасардаг байжээ. Ийм замаар зорчиход 11 сарын хугацаа ордог байв.

Үүнээс өөр зам гэвэл далайн зам байсан ба Энэтхэг, Хятад, Солонгос, Японоор дамжиж хүрдэг байлаа. Энэ аялалд 6 сар шаардагддаг байсан бөгөөд Англи, Хятад, Японтой зөрчил үүсэхэд шууд тасардаг байжээ.

1851 онд нээгдсэн Санкт-Петербургийг Москвайтай холбосон 650 км төмөр замыг байгуулах зардал 67 сая рубль байхад Оросын Засгийн газрын төсөв 200 сая рубль байсан гэдэг. Үүнтэй харьцуулбал Москвагаас Владивосток хүрэх зам 330 сая рубль болохоор байсан нь өнөөдрийн ханшаар \$7 тэрбум байжээ.

Засгийн газрыг айлгаж байсан өөр нэг зүйл бол Сибирийг хөндлөн туулахад хэдэн зуун том, жижиг гүүрийг барих хэрэгтэй байлаа. Тиймээс албаныхан Александр III хаанд энэ төслийг боломжгүй хэмээн тайлбарлаж байсан юм. Гэвч хэдхэн жилийн дараа энэ их зардлыг үл хайхран төмөр зам тавьж эхэлнэ гэж хэн ч таасангүй. 1890 оны долдугаар сард Хятадууд алс дорнодын боомт руу төмөр зам тавьж эхэлсэн тухай мэдээ Орос улсыг төмөр замын барилгын ажлыг нэн дариу, хурдтайгаар эхлүүлэх нөхцөл болсон гэдэг.

## Шинэ технологийн судалгаа

### БҮТЭЭН БАЙГУУЛАЛТ

Төмөр зам, түүнийг байгуулах ажилд 60000 ажилчин 25 жилийн хугацаанд 16 гол мөрөн, 80 орчим том жижиг хотуудыг хамарсан 9288 км үргэлжлэх асар том байгууламжийг барьж ашиглалтад оруулсан бөгөөд төмөр зам барих ажил байгалийн тогтоц саад даваа ихтэй маш хүнд хүчир ажил байсан бөгөөд ажилчдад хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хувьд ихээхэн бэрхшээл учирдаг байлаа. Ажлын цаг, цалин хөлс зэрэг нийгмийн асуудал хурцаар тавигддаг байсан бөгөөд Орос орон стратегийн чухал ач холбогдолтой энэхүү замыг барихад асар их хөрөнгө зарцуулсан нь Октябрийн хувьсгал гарахад нөлөө үзүүлсэн гэдэг.



### ЭДИЙН ЗАСГИЙН ҮР ӨГӨӨЖ

Уралаас Номхон далай хүртэл төмөр замтай болсноор Владивосток нь тив дамнасан худалдаа хийх гарц болж далайн тээвэрт оролцох боломжийг олгосон юм.

Хэдий хүндрэлтэй цаг мөч, олон саад бэрхшээлүүд учирсан ч энэ шийдвэр маш зөв байсан ба Алс Дорнодын нийгэм, эдийн засагт чухал үүрэг гүйцэтгэжээ. Төмөр замын бүтээн байгуулалт эхэлснээс тавхан жилийн дараа Владивостокийн ачаа эргэлт 30 дахин нэмэгдсэн байна. Одоо үед Транс Сибирийн төмөр зам нь Оросын экспортын 30 хувийг, аж үйлдвэрийн гарцын 80 хувийг хангаж байна.



Харин Оросуудыг яаруулахад хүргэсэн Бээжингээс умрыг чиглэх Хятадын төмөр замын ажил Транс-Сибирийн төмөр замыг байгуулснаас хойш хэдэн арван жилийн дараа дууссан гэдэг.

## Мэдээ, мэдээлэл



“Инженер-Ирээдүй” төслийн хүрээнд, нийт ажилтнууд төгөл мод тарьж, орчны хог хаягдал, бохирдлыг цэвэрлэх арга хэмжээг зохион байгууллаа.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2010 оны “Мод тарих үндэсний өдөр зарлах тухай” 63 дугаар зарлиг, Зам, тээврийн хөгжлийн сайдын 2016 оны 174 дүгээр тушаалаар баталсан “Зам, тээврийн салбарын хог хаягдлын менежментийн төлөвлөгөөг /2016-2022/ хэрэгжүүлэх, иргэдийн экологийн боловсролыг нэмэгдүүлэх улмаар байгаль дэлхийгээ хайрлан хамгаалах, зөв зохистой харилцах дадал төлөвшлийг бий болгоход хувь нэмрээ оруулах зорилгоор 2019 оны 10 дугаар сарын 04-ний өдөр “Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төв” УТҮГ, Нийслэлийн налайх дүүргийн ЗДТГ-ын “Цэцэрлэгжүүлэлтийн алба” ОНӨААТҮГ хооронд хамтран ажиллах санамж бичиг байгуулан ажиллаж байна. Уг санамж бичгийн эхний ажлын хүрээнд “Шинэ Налайх” цэцэрлэгт хүрээлэнд “ГТХЗНТ” УТҮГ -ын нэрэмжит төгөлтэй болох төслийг эхлүүлж, ажилтнуудын зүгээс мод тарьж, орчны хог хаягдал бохирдлыг цэвэрлэх арга хэмжээг зохион байгууллаа.





**Газар бизнес төвийн байр,  
Тээвэрчдийн гудамж,  
2-р хороолол, 1-р хороо,  
Баянгол дүүрэг, 16052,  
Улаанбаатар хот, Монгол улс**

